БАТЛАВ

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ К.БАХЫТЖАН

"БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ӨЛГИЙ СУМЫН ХОГ ХАЯГДЛЫН ТӨВЛӨРСӨН ЦЭГИЙН МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛАХ ЗУРАГ ТӨСӨЛ, АРГА ЗҮЙ" БОЛОВСРУУЛАХ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ АЖЛЫН ДААЛГАВАР

Нэг. Ерөнхий мэдээлэл:

Баян-Өлгий аймгийн Өлгий сум нь 13 багтай, 2025 оны байдлаар сумын суурин хүн ам 51 000 байна. Аймгийн болон сумын эдийн засаг хөгжихийн хэрээр хүн амын орлого өсөж, суманд оршин суугч иргэдийн тоо нэмэгдэхийн хэрээр сумаас үүсэх хог хаягдлын хэмжээ жил бүр өсөж байна.

Баруун бүсийн аялал жуулчлал, худалдааны томоохон төв Өлгий сумаар олон улсын чанартай авто зам дайран өнгөрч, зочид буудал, худалдаа, үйлчилгээний төвүүд олноор байгуулагдаж, гадаад дотоодын хөрөнгө оруулалт нэмэгдэж суманд ирэх жуулчдын тоо болон бизнесийн байгууллагууд цаашид эрчимтэй нэмэгдэх төлөвтэй байна.

2025 оны статистик мэдээгээр Өлгий сумаас өдөрт 200- 250тн гаруй, жилд дунжаар сумын хэмжээнд 72 000 тн -90 000 тн гаруй энгийн хатуу хог хаягдал тээвэрлэгдэж төвлөрсөн хогийн цэгт хаягдсан гэсэн бүртгэл байдаг ч төвлөрсөн хогийн цэгт хог хаягдлыг жинлэж бүртгэх автопүү байдаггүйтэй холбоотойгоор энэхүү тоо өөрчлөгдөх магадлалтай гэж үзэж байна.

Өлгий сумаас үүсч байгаа хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилагдахгүй сумын хойт зүгт, өндөрлөг газарт байрлалтай, сумын төвөөс 4 км орчим зайтай төвлөрсөн хогийн цэгт хүргэж, устгаж байгаа. 1940 оноос эхтэй манай аймгийн нэгдсэн хогийн цэг нь 6, 9 дүгээр багийн нутаг дэвсгэр болох Хүрэн зуухны аманд байрлалтай 2000 оноос зах зээлийн эдийн засагт шилжсэнээр хог хаягдлын нэр төрөл, бүтэц, бүрэлдэхүүн хэмжээ эрс нэмэгдсэн ба их хэмжээний хог хаягдал хуримтлагдаж, төвлөрсөн цэгийн үйл ажиллагаа тогтмол бус, хяналт сул байснаас шалтгаалан хогийн цэгийн хог тархалтын хэмжээ ихэссэн, органик хог хаягдлын хэмжээ үлэмж нэмэгдснээс хог хаягдал хуурайшилтын улиралд шатах, салхиар хийсэх зэргээр суурьшлын бүсийг бохирдуулсаар байна.

Үүнээс гадна сумын цэвэрлэх байгууламжийн стандарт, шаардлагыг хангахгүй 45 тн бохир, шингэн хаягдлыг өдөр бүр төвлөрсөн хогийн цэгт ил асгаж байгаа нь хүн болон халдварт өвчин дэгдэх, хөрс, усыг бохирдуулах эрсдэл үүсгэж байгаа ба дулааны улиралд үнэр нь орчны агаарын чанарыг доройтуулж, оршин суугч иргэдийн хэвийн амьдралд сөргөөр нөлөөлж байгаа юм.

Сумын хуучин хог хаягдлын төвлөрсөн цэгийг хааж, шинээр хог хаягдлын цэгийг Бугат сумын нутаг дэвсгэрт Хүрэнгийн хярт 3 га газарт газар олгосон болов

Гурав. Хугацаа:

Нийт 60 хоног хугацаанд хийж гүйцэтгэнэ.

Хугацаа	Даалгавар	Оролцогчид
7 хоног	Гэрээ байгуулах	Зөвлөх баг, сумын ЗДТГ
15 хоног	Ажлын төлөвлөгөө боловсруулах, эхлэлийн тайлан өгөх	Зөвлөх баг
45 хоног	Одоогийн ашиглаж байгаа болон шинээр байгуулах төвлөрсөн хогийн цэгийн зураглал, нөхөн сэргээлтийн төсөв боловсруулах	Зөвлөх баг
14 хоног	Иргэдийн хог хаягдлын талаарх ухамсар, мэдлэгийг нэмэгдүүлэх олон нийтийг хамарсан сургалт, семинар зохион байгуулах	Зөвлөх баг
7 хоног	Эцсийн тайлан өгөх, гэрээ дүгнэх	Зөвлөх баг, сумын ЗДТГ

Дөрөв. Мэдээлэл цуглуулах үйл ажиллагаа:

Зөвлөх баг нь шаардлагатай тоо мэдээллийг ажлын даалгаварт заасан судалгааны хүрээнд олж авах ба бусад шаардлагатай мэдээллийг Баян-Өлгий аймгийн ЗДТГ, Өлгий сумын ЗДТГ, хог хаягдлын үйлчилгээ эрхлэгч компаниудын оролцоо, тусламжтайгаар авна.

Зөвлөх нь тайлан болон судалгааны ажилд мэдээллийн эх үүсвэрийг тодорхой тусгах ба зөвлөх үйлчилгээтэй холбоотой мэдээллийг захиалагчийн зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд дамжуулахгүй байх, мэдээллийн нууцыг чанд хадгалах үүрэгтэй байна. Энэхүү зохицуулалтыг гэрээнд тусгайлан зааж өгнө.

Тав. Зөвлөх хуулийн этгээдэд тавигдах шаардлага:

- Дүрмэндээ хог хаягдлын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэхээр тусгасан байх
- Дүрэмд заасан чиг үүргийнхээ хүрээнд үйл ажиллагааг эрхэлдэг байх
- Сүүлийн нэг жилийн хугацаанд ажлын даалгаварт заасан ижил төстэй зөвлөх үйлчилгээг үзүүлсэн гэрээний дүн 100.0 сая төгрөгөөс багагүй байх
- Сүүлийн нэг жилийн хугацааны борлуулалтын орлого 300.0 сая төгрөгөөс багагүй байх
- Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө эсхүл авч болох зээлийн хэмжээ нь төсөвт өртгийн 10 хувиас багагүй байх
- Сүүлийн нэг жилийн хугацаанд ажлын даалгаварт заасан ажлуудыг хийж байсан туршлагатай байх

Зургаа. Зөвлөх багт тавигдах шаардлага:

Долоо. Санхүүжилтын хуваарь:

№	Хийгдсэн ажил	Гэрээний үнийн дүн	Он
1	Ажлын төлөвлөгөө боловсруулах, эхлэлийн тайлан өгөх	30 хувь	2026
2	Одоогийн ашиглаж байгаа болон шинээр байгуулах төвлөрсөн хогийн цэгийн зураглал, нөхөн сэргээлтийн төсөв, зардал, хөрөнгө оруулалтын тооцоо, хог хаягдлын төвлөсөн цэгийн үйл ажиллагааны арга зүй боловсруулах	40 хувь	2026
3	Сургалт, олон нийтийг хамарсан үйл ажиллагаа, эцсийн тайлан өгөх, гэрээ дүгнэх	30 хувь	2027 оны 1-р улирал

Боловсруулсан: Аймгийн Байгаль орчны газрын мэргэжилтэн М.Марина

Хянасан: Аймгийн Байгаль орчны газрын дарга Ш.Марат